

**АЗИ БОЛОН НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ ДАХЬ ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН “ЭРХИЙГ НЬ БОДИТОЙ
БОЛГОХ” ИНЧОНЫ СТРАТЕГИ**

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА

Ази болон Номхон Далайн бүсийг хариуцсан Эдийн засаг, Нийгмийн Комисс
/АНДБЭЭЗНК/

Нэгдсэн Үндэстний Байгууллагын хэвлэл
Зохиогчийн эрх © Нэгдсэн Үндэстний Байгууллага 2012
Зохиогчийн эрх баталгаажсан
Бангкок-т хэвлэв
ST/ESCAP/2648

Мэдэгдэл

Зохиогчийн эрх эзэмшигчийн бичгэн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлд орсон материалыг зар сурталчилгаа зэрэг худалдаа, арилжааны зорилгоор дахин олшруулахыг хориглоно. Дээрх зөвшөөрлийг авах хүсэлт гаргахыг хүсвэл, тус материалыг хэрэглэх болсон зорилго, ямар хэмжээгээр дахин олшруулах талаар тодорхойлсон албан бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази болон Номхон Далайн бүсийг хариуцсан Эдийн засаг, Нийгмийн Комиссын Нийгмийн Хөгжлийн Хэлтсийн даргад дараах escap-sdd@un.org хаягаар хүргүүлнэ үү.

Нэгдсэн Үндэстний Байгууллага
Ази болон Номхон Далайн бүсийг хариуцсан Эдийн засаг, Нийгмийн комисс
Бангкок, 2012 оны 11 дүгээр сар

АЗИ БОЛОН НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГТ **650 САЯ**
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮС АМЬДАРЧ БАЙНА

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн шинэ хөтөлбөрийг бид эхлүүлж байгаагын хувьд үлдэж буй сорилт, бэрхшээлүүдийг гаргаж ирж шийдвэрлэх тал дээр анхаарч ажиллацгаая.

Инчоны Стратегийг баталж хэрэгжүүлснээр 2015 оноос хойших хөгжлийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангахад та бүгд тус дөхөм үзүүлж чадах юм.

Бан Ги Мүн,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын

Ерөнхий нарийн бичгийн дарга

АНДБЭЗНК-ын талаарх танилцуулга

АНДБЭЗНК нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүсийн хөгжлийн гол байгууллага бөгөөд Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь НҮБ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол төв болж ажилладаг. Тус байгууллагын чиг үүрэг нь 53 гишүүн улс болон 9 сурвалжлагч гишүүн улс хоорондын хамтын ажиллагааг дэмжихэд оршино. АНДБЭЗНК нь олон улсын болон тодорхой улсын түвшин дэх аливаа асуудал, төсөл хөтөлбөрийг стратегийн бүсийн холбоо хэлхээгээр хангаж өгдөг. Тус Комисс нь АНДБЭЗНК ажиллаж буй бүсийн засгийн газруудын бүсийн байр суурийг бэхжүүлэхэд нь дэмжиж, даяарчлагдаж буй дэлхий дахин дахь Ази болон Номхон Далайн эдийн засаг нийгмийн сорилтуудтай тулгарах бүсийн хандлагын талаар нөлөөллийн ажиллагаа явуулдаг. АНДБЭЗНК-ын Хэрэг эрхлэх газар Бангкок-т байрладаг. Дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудас www.unescap.org –наас үзнэ үү.

АНДБЭЗНК-ын Гишүүд ба Сурвалжлагч Гишүүд

Гишүүд

Австрали
Азербайжан
Америкийн Нэгдсэн Улс
Афганистан
Армени
Бангладеш
Бутан
Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс
Бүгд Найрамдах Солонгос Улс
Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс
Бүгд Найрамдах Хятад Ард Улс
Бруней Даруссалам
Вануату
Вьетнам
Гүрж
Их Британий Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
Индонез
Иран
Казахстан
Камбож
Киргизстан
Кирибати
Малайз
Малдив
Маршаллын Арлууд
Микронези /Холбооны Улсууд/
Монгол
Мьянмар
Науру
Непал
Нидерланд
Оросын Холбооны Улс
Пакистан
Палау
Папуа Шинэ Гвиней
Самоа
Сингапур
Соломоны Арал
Тажикистан
Тайланд

Тимор Лист
Тонга
Турк
Туркменистан
Тувалу
Узбекстан
Фижи
Филиппин
Франц
Шинэ Зеланд
Шри Ланка
Энэтхэг
Япон

Сурвалжлагч гишүүд

Америкийн Самоа
Гонконг
Гуам
Күүкийн Арлууд
Макао
Ниүэ
Умарды Марианын Арлууд
Францын Полинез
Шинэ Каледони

АГУУЛГА

Танилцуулга

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны хооронд хэрэгжих 10 жилийн хөтөлбөрийн Сайд нарын Тунхаглал

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг нь бодитой болгох” Инчны Стратеги

А. Оршил

Б. Гол зарчмууд болон бодлогын чиглэл

В. Инчны Стратегийн зорилго болон зорилтууд

Г. Үр дүнтэй хэрэгжилтийг бий болгох арга замууд: үндэсний, дэд

бүсийн болон бүсийн түвшинд

- 1. Үндэсний түвшинд**
- 2. Дэд бүсийн түвшинд**
- 3. Бүсийн түвшинд**

Хавсралт

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жилийн хөтөлбөрийн Ажлын хэсгийн удирдамж

Оршил

2012 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 11 дүгээр сарын 2-ны өдрийн хооронд АНДБЭЗНК-ын бүс нутгийн засгийн газрын тэргүүн нар Солонгос улсын Инчон хотод Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн шинэ хөтөлбөрийн чиг шугамыг тодорхойлохоор цуглав. Энэхүү арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих байгууллагууд зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгч нар мөн засгийн газар хоорондын байгууллагын төлөөлөгчид, хөгжлийн хамтын ажиллагааны агентлагууд болон НҮБ-аас тус тус оролцов.

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх засгийн газар хоорондын дээд хэмжээний чуулга уулзалтыг АНДБЭЗНК болон Солонгосын засгийн газар өөрийн эх орондоо зохион байгуулав. Чуулга уулзалтаар Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 2 дахь 10 жилийн хөтөлбөрийг дүгнэж, шинэ 10 жилийн хөтөлбөрийн эхлэлийг тавьсан билээ.

Засгийн газар хоорондын дээд хэмжээний чуулга уулзалтаар засгийн газрууд Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн Сайд нарын Тунхаглал, мөн Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчоны стратегийг тус тус батлан гаргав.

Инчоны стратеги нь бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжлийн зорилгын анхны чиг шугамыг Ази, Номхон Далайн бүс нутаг болон дэлхийн хэмжээнд ийнхүү толилуулав.

Засгийн газрууд болон иргэний нийгмийн төлөөлөлтэй 2 жил гаруй зөвлөлдөсний үндсэн дээр, Инчоны стратегийг 10 зорилго, 27 зорилт болон 62 шалгуур үзүүлэлттэйгээр боловсруулан гаргав.

Инчоны стратегийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон Бивако-гийн Мянганы Хүрээн дэх Үйл Ажиллагаа, мөн Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан оролцоотой, саадгүй, эрхэд суурилсан нийгмийг чиг болгосон Бивако-гийн нэмэлт 5 зарчим дээр тулгуурлаж боловсруулсан юм.

Инчоны стратеги нь Ази болон Номхон Далайн бүс нутагт амьдарч буй дийлэнх нь ядуу амьдралтай 650 сая хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьжиргааны чанарыг сайжруулах, эрхийг нь хэрэгжүүлэхэд гарах ахиц дэвшлийг тус бүс нутагт гаргах боломжийг бий болгож байгаа юм. АНДБЭЗНК-ын Хэрэг эрхлэх газар нь Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийн явцыг

тус хөтөлбөрийн 10 жилийн хугацаанд 3 жил тутам буюу 2022 оны сүүл хүртэл тайлагнах үүрэгтэй юм.

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн Сайд нарын Тунхаглал

Бид буюу засгийн газрын сайд нар болон АНДБЭЗНК-ын (ESCAP) гишүүн ба сурвалжлагч гишүүн орны төлөөлөгчид Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтаар 2013 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 11 дүгээр сарын 2-ны өдөр хүртэл Солонгосын Инчон хотод цугларан,

Дахин дурьдах нь Ерөнхий Ассамблейн 1982 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 37/52 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн¹ талаарх Дэлхийн Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батласан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бүх салбар дахь хөгжлийн агент болон ашиг хүртэгч хүмүүс гэж хүлээн зөвшөөрсөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломж бололцоог тэгшитгэх стандарт дүрмийг Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48/96 тоот тушаалаар батласан,

Мөн дахин дурьдах нь Ерөнхий Ассамблейн 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 61/106 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон 2008 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болсон түүний Нэмэлт Протоколыг батласан,

Цаашид дурьдах нь “Амлалтаа биелүүлэх нь: Мянганы Хөгжлийн Зорилтод хүрэхийн тулд нэгдэх нь” нэртэй Ерөнхий Ассамблейн 2010 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 65/1 тоот тушаалд бодлого, үйл ажиллагаа нь ядуурал болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг маш эмзэг нөхцөл байдалд амьдарч буй хүмүүст чиглэх ёстой бөгөөд ингэснээр тэд Мянганы Хөгжлийн Зорилтод хүрэхэд чиглэсэн ахиц дэвшлээс ашиг хүртэх ёстой гэж Ассамблей хүлээн зөвшөөрчээ,

Талархан дэмжих нь Мянганы Хөгжлийн Зорилт болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан бусад олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хөгжлийн зорилтын хэрэгжилтийн талаарх дээд хэмжээний уулзалтыг 2013 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр “Урагшлах зам: 2015 он ба цаашид чиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй оролцоотой хөгжлийн хөтөлбөр”

¹ А/37/351/ Нэмэлт 1 ба Засвар 1, хавсралт, секц VIII, зөвлөмж 1 (IV)

нэртэйгээр² төр, засгийн газрын тэргүүн нарын хэмжээнд зохион байгуулах тухай Ерөнхий Ассамблейн шийдвэр,

Дахин дурьдах нь Ерөнхий Ассамблейн 2012 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр батласан 66/290 тоот тушаалд хүний аюулгүй байдлын талаарх нэгдсэн ойлголтыг гаргаж тавьсан бөгөөд түүнчлэн хувь хүмүүс, тухайлан эмзэг бүлгийн хүмүүс айдсаас ангид байх эрх чөлөө, ядуурлаас ангид байх эрхтэй бөгөөд тэд бүх эрхээ эдлэх болон хувь хүний нөөц бололцоогоо бүрэн хөгжүүлэх тэгш боломжтой гэж заасан,

Мөн дахин дурьдах нь Хүний эрхийн Комиссийн 1992 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 48/3 тоот тушаалаар Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 1993-2002 оны 10 жилийн хөтөлбөрийг батласан бөгөөд Комисс бүс нутгийн хэмжээнд хийгдэх анхны 10 жилийн хөтөлбөрийг дэлхий дахинд тунхаглав,

Цаашид дахин дурьдах нь Хүний эрхийн Комиссийн 2002 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 58/4 тоот тушаалаар 21 дүгээр зуунд Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан оролцоотой, саадгүй, эрхэд суурилсан нийгмийг хөхиүлэн дэмжих бөгөөд үүнд Комиссоос 2003-2012 онд хэрэгжүүлэх Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан дараагийн 10 жилийн хөтөлбөрийн үргэлжлэлийг тунхаглав,

Дахин дурьдах нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийн хугацаанд Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан оролцоотой, саадгүй, эрхэд суурилсан нийгмийг чиг болгосон Бивако-гийн Мянганы Хүрээн дэх Үйл Ажиллагааны бүс нутаг дахь хэрэгжилтийн талаарх Комиссийн 2003 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 59/3 тоот тушаал болон үүнд Комиссоос Бивако-гийн Мянганы Хүрээн дэх Үйл Ажиллагааны хэрэгжилтийг гишүүн болон сурвалжлагч гишүүн орнуудаас дэмжихийг уриалав,

Мөн түүнчлэн дахин дурьдах нь Бивако-гийн Мянганы Хүрээн дэх Үйл Ажиллагаа болон Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан оролцоотой, саадгүй, эрхэд суурилсан нийгмийг чиг болгосон Бивако-гийн нэмэлт 5 зарчмын бүс нутаг дахь хэрэгжилтийн талаарх Комиссийн 2008 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 64/8 тоот тушаал болон үүнд Комисс нь Ази болон Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийг оролцуулан Бивако-гийн Мянганы Хүрээн дэх Үйл Ажиллагаа болон Бивако-

² 2011 оны 12 сарын 19-ны өдрийн Ерөнхий Ассамблейн 66/124 тоот тушаалыг үзэх

гийн нэмэлт 5 зарчмын хэрэгжилтийг авч хэлэлцэх засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулах чиг үүрэгтэй,

Цаашид дахин дурьдах нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эцэслэн дүгнэх засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтыг бүс нутгийн хэмжээнд бэлтгэх тухай Комиссийн 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 66/11 тоот тушаал болон үүнд Комиссоос засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулах бэлтгэл үйл ажиллагаанд Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага зэрэг холбогдох бүх талуудыг оролцуулах явдлыг дэмжсэн,

Дахин дурьдах нь Комиссийн 2012 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 68/7 тоот тушаалаар Комисс нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийг тунхаглаж, бүх гишүүн болон сурвалжлагч гишүүн орнуудыг засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтанд идэвхитэй оролцох, мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод туссан ерөнхий зарчим болон үүрэг хариуцлагад үндэслэн 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах стратегийн хүрээг гаргаж ирж, батлахыг сануулав,

Цохон тэмдэглэх нь *Хөгжлийн бэрхшээлийн талаарх Дэлхийн Тайланд* дэлхийн хүн амын ойролцоогоор 15% нь аливаа нэг хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй гэж гарсан бөгөөд үүнээс Ази болон Номхон Далайн бүс нутагт 650 сая хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаа буюу тэдний 80% нь хөгжиж буй орнуудад³ амьдарч байна,

Талархан дэмжих нь Ази болон Номхон Далайн бүс нутагт 1993-2012 оны хооронд 10 жилийн хоёр хөтөлбөрийг оролцооны хөгжил ялангуяа бодлого болон байгууллагын үүрэг амлалт, хууль тогтоомж болон эрх мэдэлжүүлэлтэд гарсан шинэ алхмаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэр хүндэд анхаарсан, эрхэд суурилсан хандлагын үндсийг бий болгосон АНДБЭЗНК-ын гишүүн болон сурвалжлагч гишүүн орнууд амжилттай хэрэгжүүлж ахиц дэвшил гарсан,

Цохон тэмдэглэх нь янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар иргэдийн мэдлэг ойлголтыг байнга дээшлүүлж, сайн туршлагыг санаачлан бий болгож, мөн бодлогын яриа хэлэлцээрт оролцож амжилт гаргахад хувь нэмэр оруулсан иргэний нийгмийн байгууллага тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих байгууллагад талархаж байна,

Харгалзан үзэх нь Порта Вила-д болсон Номхон Далайн Арлуудын 41 дэх Чуулган дээр Номхон Далайн бүс нутгийн тэргүүн нар 2010 оны 8 дугаар сарын

³ Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага/Дэлхийн Банк, Хөгжлийн бэрхшээлийн тухай Дэлхийн Тайлан (Женев: Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага, 2011), х.29

5-ны өдрийн Албан мэдээнд⁴ тулгуурлан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, Номхон Далайн бүс нутагт хөгжлийн бэрхшээлийн оролцоог бий болгох зохицуулалтын үйл ажиллагааг хангах, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон хөгжлийн бэрхшээлтэй холбоотой бусад хүний эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд холбогдох талуудын үүрэг амлалтыг бэхжүүлэхийн тулд Хөгжлийн бэрхшээлийн талаарх 2010-2015⁵ оны Номхон Далайн бүс нутгийн Стратегийг ихээхэн дэмжиж байгаагаа дахин илэрхийлэв,

Талархан цохон тэмдэглэх нь Индонезийн Бали аралд болсон 19 дэх дээд хэмжээний уулзалт дээр Зүүн-Өмнөд Азийн улсуудын Холбооноос (ASEAN) 2011 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр ASEAN-ны Нийгэмлэгт⁶ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх тухай Балийн Тунхаглалыг батласан бөгөөд уг дээд хэмжээний уулзалтаар ASEAN-ны Нийгэмлэгийн тулгуур болох эдийн засаг, улс төрийн аюулгүй байдал болон нийгэм-соёлын ASEAN-ны бодлого хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үр дүнтэй оролцоог хангах болон хөгжлийн бэрхшээлийн чиг хандлагыг дэмжихэд чиглэж ASEAN-ны Холбоо нь 2011-2020 оныг ASEAN-ны орнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жил болгож тунхаглав,

Талархан дэмжиж буй нь Солонгос улсын Пусан хотод 2011 оны 12 дугаар сарын 1-ний өдөр болсон Үр дүнтэй тусламж нэртэй 4 дэх удаагийн дээд хэмжээний уулзалтаар Үр дүнтэй хөгжлийн хамтын ажиллагааны талаарх Пусаны түншлэл⁷ нэртэй баримт бичгийг батласан бөгөөд уг баримт бичгээр үр дүнтэй хөгжлийн хамтын ажиллагааны үндэс суурийг бий болгоход хөгжлийн бэрхшээлийн талаарх олон улсын үүрэг амлалт чухал болохыг хүлээн зөвшөөрөв,

Түүнчлэн талархан дэмжиж буй нь “саад бэрхшээлийг халж, оролцоог хөхиүлэн дэмжие” сэдвийн дор 2012 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Бээжингийн Чуулга уулзалтаар Хөгжил дэх хөгжлийн бэрхшээлийн оролцооны тухай Бээжингийн Тунхаглалыг⁸ батласан бөгөөд үүгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг соёрхон баталж, хэрэгжүүлэх үйл явцыг эрчимжүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, мөн 2015 оноос хойш НҮБ-ын хөгжлийн бодлогын янз бүрийн салбарт хөгжлийн бэрхшээлийн хүрээг тусгахыг чухалчлав,

⁴ www.forumsec.org/resources/uploads/attachments/documents/2010_Forum_Communique.pdf.

⁵ Номхон далайн арлуудын Чуулга уулзалтын Нарийн бичгийн дарга нарын газар, баримт бичиг PIFS (09)FDMM.07 (www.forumsec.org.fj. – харж болно)

⁶ www.aseansec.org/documents/19th%20summit/Bali_Declaration_on_Disabled_Person.pdf. -ийг хар

⁷ www.aideffectiveness.org/busanhlf4/images/stories/hlf4/OUTCOME_DOCUMENT_-_FINAL_EN.pdf. -ийг хар

⁸ E/ESCAP/APDDP(3)/INF/5. -ийг хар

Цохон тэмдэглэх нь Олон нийтэд суурилсан Сэргээн засварлах гарын авлага⁹ нь Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага, Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага /ЮНЕСКО/ болон Олон улсын Хөгжлийн Бэрхшээл болон Хөгжлийн Консорциум гэсэн байгууллагуудын хамтын баримт бичиг бөгөөд энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх олон салбарыг хамарсан ядуурлыг бууруулах нэгдсэн стратегийг хангаж өгсөн,

Дахин дурьдах нь 2012 оны 6 дугаар сарын 22-ны өдөр НҮБ-ын Бага хурлаас батласан “Бидний хүсч буй ирээдүй”¹⁰ нэртэй тогтвортой хөгжлийн талаарх НҮБ-ын Бага хурлын үр дүнгийн баримт бичиг бөгөөд тус баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тодорхойлж, тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээнд тэдний оролцох эрхийг нь хүлээн зөвшөөрөв,

Цохон тэмдэглэх нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эдийн засаг, нийгмийн боломж, улс төрийн оролцоо болон амьдралын бусад олон зүйлс ижил тэгш хүртээмжтэй байх эрхтэй гэдгийг хангахын тулд олон сорилт бэрхшээл байсаар байгааг анхаарах,

Тооцож үзэх нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хурдацтай хүн амын хөгшрөлтийн урт хугацааны үр дүнд хөгжлийн бэрхшээлийн цар хүрээг анхаарч шийдвэрлэх хэрэгтэй,

Цохон тэмдэглэх нь онцгой анхаарах асуудал нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гамшгийн нөлөөнд харилцан адилгүй өртөж байгаа бөгөөд сүүлийн 30 жилд тус бүс нутаг хэд хэдэн томоохон гамшигт нэрвэгдсэн,

Түүнчлэн цохон тэмдэглэх нь онцгой анхаарах асуудал нь одоог хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх нийгмийн сөрөг хэвшмэл ойлголт, тэднийг ялгаварлан гадуурхах байдал давамгайлж байсаар байна,

Санаа тавьж буй нь хүрээлэн буй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцаа холбооны хүртээмжийг сайжруулах шинэ техник технологи ашиглах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах боломж нэмэгдэж байна,

1. *Батлах* нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчоны стратеги бөгөөд энэ нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-

⁹ www.who.int/disabilities/cbr/guidelines/en/index.html. -ийг хар

¹⁰ 2012 оны 7 сарын 27-ны өдрийн 66/288 тоот Ерөнхий Ассамблейн Тунхаглал-ыг хар

2022 оны шинэ 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад Ази болон Номхон далайн бүс нутаг дахь бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хөхиүлэн дэмжих оролцоог хангасан нийгмийн бүс нутгийн хэтийн төлвийн ололт амжилтыг бий болгох явцыг эрчимжүүлэх арга хэмжээг авах хэрэгтэй;

2. *Хүлээн зөвшөөрөх* нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хөхиүлэн дэмжихэд мөн 2015 оноос хойш янз бүрийн салбарт хөгжлийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн хүрээг оролцуулахыг хөхиүлэн дэмжихэд засгийн газрын гол гүйцэтгэх үүргийг;

3. *Үүрэг авах нь* Инчоны зорилго, зорилтод хүрэх үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих замаар 2022 он гэхэд одоогийн Тунхаглал болон Инчоны стратегийг хэрэгжүүлэх;

4. *Урих* нь доор дурдсан холбогдох бүх талуудыг бүсийн хэмжээний түншлэлд нэгдэн орж одоогийн Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах:

а АНДБЭЗНК-ын зохицуулалтын дор хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжлийн төлөөх дэд бүс нутаг дахь хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, бэхжүүлэх зорилго бүхий дэд бүсийн засгийн газар хоорондын байгууллагууд болох Зүүн-Өмнөд Азийн улсуудын холбоо, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Номхон Далайн Арлуудын Форум болон Бүс нутгийн хамтын ажиллагааны Өмнөд Азийн Холбоо;

б Өөрсдийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн оролцоог бэхжүүлэх Хөгжлийн хамтын ажиллагааны агентлагууд;

в Ази болон Номхон Далайн бүс нутагт хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжлийг хөхиүлэн дэмжихэд өөрсдийн техник болон санхүүгийн нөөц бололцоог ашиглах Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банк;

г НҮБ-ын тогтолцоо буюу үүнд НҮБ-ын хөтөлбөр, сангууд, тусгайлсан агентлагууд болон АНДБЭЗНК орох ба НҮБ-ын Хөгжлийн Баг, НҮБ-ын аливаа улс оронд ажиллаж буй байгууллага зэрэг үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд ажиллаж буй механизмуудыг үр дүнтэй ашиглах замаар Ази болон Номхон Далайн бүс нутагт хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжлийг хамтран түгээх;

д Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүсэл эрмэлзлэл, хэрэгцээ шаардлагыг байнга анхаарч байх үүднээс янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлгүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх мөн хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах болон эдгээрийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулах замаар 10 жилийн Хөтөлбөрт хяналт тавьж, үнэлгээ өгөхөд үр дүнтэйгээр оролцох иргэний нийгмийн байгууллагууд, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийг дэмжих байгууллага орно;

е Инчоны Стратегитэй хамааралтай аливаа шийдвэр гаргах үйл явцад Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийг дэмжих байгууллагууд идэвхитэй оролцох;

ё Аж ахуйн нэгж байгууллагууд хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан бизнесийн туршлагыг хөхиүлэн дэмжих;

5. *Хүсэлт тавих нь* АНДБЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн даргыг:

а Одоогийн Тунхаглал болон Инчоны Стратегийг бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэхэд бусад холбогдох байгууллагуудтай хамтран гишүүд болон сурвалжлагч гишүүдийг дэмжих асуудлыг нэн тэргүүнд тавих;

б Одоогийн Тунхаглал болон Инчоны Стратегийн хэрэгжүүлэхэд холбогдох талуудыг татан оруулж, тэдгээрийн оролцоог дэмжих;

в Засгийн газар хоорондын энэхүү дээд хэмжээний уулзалтын үр дүнгийн баримт бичгийг батлуулахаар 69 дэх Чуулганы хуралдаанаар Комисст хүргүүлэх;

г Ерөнхий Ассамблейн Ерөнхийлөгчөөр дамжуулан Засгийн газар хоорондын энэхүү дээд хэмжээний уулзалтын үр дүн баримт бичгийг 2013 оны 9 сарын 23-ны өдөр болох Мянганы Хөгжлийн Зорилт болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан олон улсын хэмжээнд батласан бусад хөгжлийн зорилтын хэрэгжилтийг авч хэлэлцэх дээд хэмжээний уулзалтад хүргүүлэх;

д Одоогийн Тунхаглал болон Инчоны Стратегийн хэрэгжүүлэхэд гарч буй ахиц дэвшлийн талаар 10 жилийн хөтөлбөрийг дуустал 3 жил тутам Комисст тайлагнах;

е Комиссийн 70 дахь Чуулганы хуралдаанаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчоны Стратегийн хэрэгжилтийн талаарх тайлагнахад, тайлагналтын шаардлага бүхий удирдамж боловсруулах;

б. *Санал болгох нь* Комисс 69 дэх Чуулганы хуралдаанаар 10 жилийн хөтөлбөрийн дунд үед (2017) хэрэгжилтийн ахиц дэвшлийг хэлэлцэх болон хөтөлбөрийн төгсгөлийн дүгнэлтийг (2022) хийх засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулах тал дээр шийдвэр гаргах.

**Ази болон Номхон Далайн бүс
нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй
хүмүүсийн “Эрхийг нь бодитой
болгох” Инчоны Стратеги**

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь

бодитой болгох” Инчоны Стратеги нь

<p>Хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжил болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг соёрхон батлуулах, хэрэгжүүлэх явдлыг эрчимжүүлэх зорилготой</p>	<p>20 жилийн туршлагаас гарч ирсэн: Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жилийн хөтөлбөр: 1993-2002 ба 2003-2012</p>	<p>Гол онцлог: цаг хугацааны хүрээтэй ба хэмжигдэхүйц Инчоны зорилго ба зорилтууд</p>
<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн зарчимд суурилсан</p>	<p>Зорилгод хүрэх цаг хугацааны хүрээ: Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жилийн хөтөлбөр, 2013-2022</p>	<p>Ази-Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангахад дараах түншлэлүүд байх ёстой: *олон талт салбар бүхий *олон талд холбогдох талууд *олон талын түвшинд</p>

“Эрхийг нь бодитой болгох” 10 зорилго

<p style="text-align: center;">1</p> <p>Ядуурлыг бууруулах, Ажил болон ажлын байрыг бий болгох асуудлыг сайжруулах</p>	<p style="text-align: center;">2</p> <p>Улс төрийн болон шийдвэр гаргах үйл явц дахь оролцоог хөхиүлэн дэмжих</p>	<p style="text-align: center;">3</p> <p>Хүрээлэн буй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл болон харилцаа холбооны хүртээмжийг сайжруулах</p>
<p style="text-align: center;">4</p> <p>Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх</p>	<p style="text-align: center;">5</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүд болон тэдний гэр бүлийг дэмжих тогтолцоо болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролыг өргөжүүлэх</p>	
<p style="text-align: center;">6</p> <p>Жендэрийн эрх тэгш байдал болон эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх явдлыг хангах</p>	<p style="text-align: center;">7</p> <p>Гамшгийн эрсдлийг бууруулах болон менежментэд хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангах</p>	<p style="text-align: center;">8</p> <p>Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийн сангийн үнэн бодит байдал болон харьцуулсан тоо баримтыг сайжруулах</p>
<p style="text-align: center;">9</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг соёрхон батлуулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, үндэсний хууль тогтоомжийг Конвенцтой нийцүүлэх</p>		<p style="text-align: center;">10</p> <p>Дэд бүс нутгийн, бүс нутаг болон бүс нутаг хоорондын хамтын ажиллагааг сайжруулах</p>

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчоны стратеги

А Оршил

- 1** Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчоны стратегийг Ази болон Номхон Далайн бүс нутагт орших хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан 1993-2002 он ба 2003-2012 онуудад дарааллан хэрэгжүүлсэн 10 жилийн 2 хөтөлбөрийн туршлага болон 2006 онд Ерөнхий Ассамблейн батласан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид ¹¹ суурилж боловсруулсан.
- 2** Инчоны стратегийг боловсруулахад улс орны засгийн газрууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага ба тэдгээрийн дэмжих байгууллага, мөн бусад холбогдох талууд хувь нэмэр оруулсан. Уг стратегийг бүс нутгийн дараах газруудын зөвлөлдөх уулзалтаас гарсан санал зөвлөмж, ажиглалт дээр үндэслэж боловсруулсан. Үүнд: Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах Холбогдох талуудын зөвлөлдөх уулзалтын экспертын баг: Бивакогийн Мянганы хүрээн дэх үйл ажиллагаа (Бангкок, 2010 оны 6 дугаар сарын 23-25); Нийгмийн Хөгжлийн Хороо, 2 дахь чуулга уулзалт (Бангкок, 2010 оны 10 дугаар сарын 19-21); Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийг дүгнэх засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтын Бүс нутгийн холбогдох талуудын зөвлөгөөн (2011 оны 12 сарын 14-16); Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулах бүс нутгийн бэлтгэх уулзалт (Бангкок, 2012 оны 3 дугаар сарын 14-16).
- 3** Улс орны засгийн газрууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийг дэмжих байгууллагаас Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийн эцэслэн дүгнэх асуудлаарх

¹ Ерөнхий Ассамблейн Тунхаглал 61/106, хавсралт 1.

2011-2012 оны АНДБЭЗНК-ын Хөгжлийн бэрхшээлийн судалгаанд өгсөн арвин баримт мэдээлэл, санал нь Инчоны Стратегийг боловсруулах суурийг тавьж өгсөн.

- 4 Инчоны Стратеги нь Бивакогийн Мянганы хүрээн дэх үйл ажиллагаа болон Ази болон Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоотой, саадгүй, эрхэд суурилсан нийгмийг чиглэсэн Бивакогийн нэмэлт 5 зарчим болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид бүрэн дүүрэн туссан асуудлыг давтахыг зориогүй бөгөөд дээрх баримт бичгүүд нь бүгд хөгжлийн бэрхшээлийн салбар дахь бүс нутгийн үйл ажиллагаанд бүгдийг хамарсан бодлогын баримт бичгийн хувиар байнга үйлчилсээр байх болно.

Мянганы Хөгжлийн Зорилттой ¹² нэгэн адил, Инчоны зорилго, зорилтууд нь 2013-2022 оны шинэ 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хэд хэдэн нэн тэргүүний зорилго, зорилтод хүрэхэд онцгой анхаарал хандуулах мөн Ази Номхон Далайн бүс нутаг дахь улс орон, нутаг дэвсгэрт гарч буй ахиц дэвшлийг хэмжих явдлыг хялбаршуулах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх цаг хугацааны хүрээтэй юм.

Б Гол зарчмууд болон бодлогын чиг шугам

Инчоны Стратеги нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн дараах зарчимд тулгуурласан:

- а. Өөрийн сонголтоо хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдал зэрэг хүний заяагдмал нэр төр, хувь хүний хараат бус байдлыг хүндэтгэх;
- б. үл ялгаварлан гадуурхалт;
- в. нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэйгээр хамрагдан оролцох;
- г. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ялгаатай байдал болон тэдгээрийг хүлээн зөвшөөрөх нь хүмүүний онцлог ялгаатай байдал болон хүмүүнлэгийн нэг хэсэг гэдэг үүднээс хүндэтгэх;
- д. ижил тэгш боломж;

¹² Мянганы Хөгжлийн Зорилт нь 8 зорилт, 21 зорилго, 60 заалттай.

е. хүртээмжтэй байдал;

ё. эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын ижил тэгш байдал;

ж. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн чадавхийг хөгжүүлэх явдлыг хүндэтгэх мөн тэднийг өөрсдийнхөө өвөрмөц илэрхийллээ хадгалуулах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хүндлэх.

7 Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалж, бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд Инчоны Стратеги нь дараах бодлогын чиг шугамыг дэвшүүлж байна. Үүнд:

а. Эрхийн хэрэгжилтийг дэмжихүйц эрх зүйн, засаг захиргааны болон бусад арга хэмжээг баталж, хэрэгжүүлж, хянаж, мөн сайжруулснаар хөгжлийн бэрхшээлд суурилсан ялгаварлан гадуурхалт арилна;

б. Хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан, жендерийн мэдрэмжтэй хөгжлийн бодлого болон хөтөлбөр, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ эдлэх боломжийг олгох технологийн дэвшилтийг дэлхийн дахины загвартай хослуулах боломжийг ашиглах;

в. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндсэн хэрэгцээ болон ядуу нөхцөлд амьдарч буй тэдгээрийн гэр бүлийн асуудлыг анхаарч шийдвэрлэх хөгжлийн бодлого болон хөтөлбөр;

г. Бодит үндэслэлтэй бодлого боловсруулахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүйсийн ялгааны талаарх тоо баримтад үр нөлөөтэй, тогтмол дүн шинжилгээ хийх;

д. Үндэсний, дэд үндэсний болон орон нутгийн бодлого, хөтөлбөр нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хамарсан, холбогдох шийдвэр гаргах үйл ажиллагаанд тэдний төлөөлөх байгууллагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог нэн тэргүүнд тавьсан төлөвлөгөөнд үндэслэх;

е. Холбогдох санхүүгийн дэмжлэгийг хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан бүхий хөгжлийн бүх үе шатанд үзүүлэх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамарсан татварын бодлогыг хөнгөвчлөх;

ё. Хөгжилд хамаарал бүхий үндэсний, дэд бүсийн, бүс нутгийн болон олон улсын байгууллагууд нь өөрийн бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн хүрээг оруулах;

ж. 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хянах мөн холбогдох сайн туршлагыг хуваалцах үүднээс дэд бүс болон бүс нутгийн холбоо бүхий үндэсний, үндэсний түвшний болон орон нутгийн зохион байгуулалт нь олон талт салбарын зөвлөгөөн, хамтын ажиллагааг эрчимжүүлэх замаар

хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжлийн бодлого болон хөтөлбөрийг бэхжүүлэх явдлыг хангах;

з. Нийгэм, эдийн засгийн статус, шашин шүтлэгийн холбоо хамаарал, гарал үүсэл болон оршин тогтнож буй газраас үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс нь бусадтай нэгэн адил хөгжлийн санаачлагын төсөл хөтөлбөр, ялангуяа ядуурлыг бууруулах аливаа хөтөлбөрт хувь нэмрээ оруулах мөн дээрх хөтөлбөрөөс ашиг хүртэх явдлыг хангах үүднээс хамт олон ба гэр бүлд суурилсан оролцоог хамарсан хөгжлийг хөхиүлэн дэмжих;

и. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хамт олны амьдралын зонхилох чиг хандлагад хамрагдах бөгөөд тэднийг бусадтай адил бие даан амьдрах бүхий амьдралын сонголтоор дэмжинэ;

к. Хүрээлэн буй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцаа холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ашиглаж болохуйц хэлбэрээр хүртээмжтэй байх бөгөөд дэлхийн дахинд хэрэглэж буй хийц загвар болон туслах технологи бүхий тохиромжтой байр сууцыг хангаж мөн тэдний эрхийг хангахад чухал гүүрийг бий болгох эдийн засаг, газар зүй, хэл зүй болон соёлын бусад олон янзын шинж байдлыг хамруулах хэрэгцээг анхаарах хэрэгтэй;

л. Янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй бүлэгт дараах төрлийн бүлэг орж байгаа ч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: хөгжлийн бэрхшээлтэй охид хөвгүүд, хөгжлийн бэрхшээлтэй залуу хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, оюун ухааны болон сурах, хөгжих бэрхшээлтэй хүмүүс, аутизмтай хүмүүс, сэтгэл зүй-нийгмийн бэрхшээлтэй хүмүүс, дүлий, сонсгол муутай болон дүлийрсэн хүмүүс, хараагүй дүлий хүмүүс, олон талын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өргөн хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй өндөр настай хүмүүс, БЗХӨ-тэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, халдварт бус өвчнөөс үүссэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, уяман өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмчилгээний нөхцлөөс үүссэн болон эдгэшгүй унадаг өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, зам тээврийн ослоос үүссэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй уугуул нутгийн иргэд болон үндэсний цөөнх хүмүүс, гэр оронгүй болон зохих орон байргүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн онц байдал, байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшгийн нөхцөл байдал гэх эрсдэлтэй нөхцөл байдалд буй 5хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, газар доорх уурхайн хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хууль эрх зүйн статусгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, гэр бүлийн өмгөөллийн баг болон ядуусын хороолол, хотын зах, алслагдсан газар, далайн атол-аралд амьдарч буй нийгмээс орхигдсон/гадуурхагдсан/ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс;

м. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийг дэмжих байгууллага, бие даасан дэмжих бүлэг, бие даасан өмгөөлөх бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл болон харгалзан асрагч нарын хүсэлтийн дагуу дэмжлэгийг авч шийдвэр гаргах үйл явцад оролцож, нийгмээс орхигдон амьдарч буй хүмүүсийн ашиг сонирхолыг зохистой анхаарч шийдвэрлэх асуудлыг гаргаж тавих явдлыг хангах;

н. Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хэв загвар дахь олон талт салбарын хандлага, зан үйлийг сайжруулах, тэднийг үр дүнтэйгээр татан оролцуулахын тулд санхүүгийн зохистой нөөцийг бий болгох замаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг бэхжүүлж, тогтмол явуулах.

В Инчны зорилго болон зорилтууд

8 Инчны стратеги нь уялдаа холбоо бүхий 10 зорилго, 17 зорилт болон 62 шалгуур үзүүлэлтээс бүрдэнэ.

9 Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жилийн хөтөлбөрийн зорилго болон зорилтод хүрэх цаг хугацааны хүрээ нь 2013-2022 оныг хамрана.

10 Зорилго нь хүрэх эцсийн үр дүнг тодорхойлдог. Зорилтыг товолсон цаг хугацаанд хэрэгжүүлэх ёстой. Шалгуур үзүүлэлт нь зорилтод хүрэхэд гарах ахиц дэвшлийг хэмжих ба зорилтод хүрсэн гэдгийг батлана. Хоёр төрлийн шалгуур үзүүлэлт бий. Үүнд: гол шалгуур үзүүлэлт болон нэмэлт шалгуур үзүүлэлт гэж байдаг¹³. Бүх шалгуур үзүүлэлт нь аль болох хүйсийн ялгаагаар зааглагдсан байх ёстой.

Зорилго 1

Ядуурлыг бууруулах, ажил болон ажлын байрыг бий болгох асуудлыг сайжруулах

11 10 жилийн хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийн гэр бүл дэх ядуурлыг бууруулахад ихээхэн ахиц дэвшил гаргахыг зорьж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хөдөлмөрийн зах зээл дээрх сул талуудыг

¹³ Гол шалгуур үзүүлэлтүүд нь шинэ 10 жилийн хөтөлбөрийн явцад улс орнууд хоорондоо хэрэгжилтийн ахиц дэвшлийн талаар туршлага солилцоход дөхөм үзүүлнэ; эдгээр шалгуур үзүүлэлт нь аливаа хүчин чармайлтаас үүдэн гарсан мэдээллийн санд зориулагдсан. Нэмэлт шалгуур үзүүлэлтүүд нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн адил нөхцөлтэй улс орнуудын дунд гарах ахиц дэвшил гаргахад дөхөм үзүүлж болох бөгөөд мэдээллийн санг бүрдүүлэхэд амаргүй байх болно.

ихээхэн мэдэрдэг, эдийн засгийн оролцоо багатай бөгөөд үүнээс үүдэн хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийг бодвол харьцангуй ядуу байдаг байна.

Боломжийн сайн ажилтай байж, тухайн ажлын байраа хадгалан үлдэхэд шаардагдах боловсрол, сургалт болон туслалцаа дэмжлэг нь ядуурлыг даван туулах хамгийн сайн арга замуудын нэг юм.

Ажиллаж чадах, ажиллах хүсэлтэй хүмүүсийг илүү дэмжиж, хамгаалж мөн тэдгээр хүмүүс нь тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадвартай байх ёстой. Үүний тулд хөдөлмөрийн зах зээлийг илүү ихээр бий болгох шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийг ядуурлаас гаргах нь оролцооны өсөлт болон тогтвортой хөгжилд хүрэхэд хувь нэмэр оруулах юм.

Зорилт 1. А

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ядуурлыг бууруулах.

Зорилт 1. Б

Ажиллаж чадах, ажиллах хүсэлтэй ажиллах насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх.

Зорилт 1. В

Засгийн газраас санхүүжүүлдэг мэргэшлийн сургалт болон бусад ажил эрхлэлтийг дэмжих бусад хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх.

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

1.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь олон улсын ядуурлын түвшнээс доогуур буюу өдрийн 1.25 ам.доллороос доош орлоготой амьдарч байна гэсэн тоо баримтыг Дэлхийн Банк гаргаж, нийт хүн амтай харьцуулалт хийжээ

1.2 Ажил эрхэлж буй үндсэн хүн амтай хөгжлийн бэрхшээлтэй хүн амын ажил эрхлэлтийг харьцуулах

1.3 Засгийн газрын санхүүжүүлдэг мэргэшлийн сургалт болон ажил эрхлэлтийг дэмжих бусад хөтөлбөрт оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоог сургалтанд хамрагдсан бүх хүмүүсийн тоотой харьцуулах

Нэмэлт шалгуур үзүүлэлтүүд

1.4 Үндэсний хэмжээн дэх ядуурлын түвшнээс доогуур түвшинд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон үзүүлэлт

Зорилго 2

Улс төрийн болон шийдвэр гаргах үйл явц дахь оролцоог хөхиүлэн дэмжих

12 Улс төрийн болон шийдвэр гаргах үйл явц дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хэрэгжүүлэх тулгын чулуу нь юм. Сонгох, сонгогдох эрхээ эдлэх нь энэхүү зорилгод хүрэхэд маш чухал зүйл юм. 10 жилийн хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, залуус гэх янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй бүлгийн хүмүүсийн улс төрийн болон шийдвэр гаргах бүх түвшинд илүү өргөн хүрээтэй оролцоо оролцоо нэмэгдэх болно. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон нийтийн шийдвэр гаргах үйл явцад оролцуулах, мөн тэднийг нийгмийн гишүүний хувьд эрх, үүргээ биелүүлэх боломжийг бий болгохын тулд технологийн дэвшилтийг ашиглах хэрэгтэй юм. Технологийн дэвшилт гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дээд шүүх, яамд болон үндэсний хуулийн байгууллага гэх засгийн газрын шүүх, гүйцэтгэх, хууль тогтоох байгууллагад албан тушаалд томилогдох ижил тэгш хүртээмжтэй орчныг бий болгох явдал юм.

Зорилт 2.А

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь засгийн газрын шийдвэр гаргах байгууллагад төлөөлөлтэй байх явдлыг хангах

Зорилт 2.Б

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн үйл явц дахь оролцоог сайжруулахад чиглэсэн зүйд нийцэхүйц зохицуулалтыг бий болгох

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

2.1 Парламент аль эсвэл үүнтэй адил үндэсний хууль тогтоох байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзэлж буй суудлын харьцаа

- 2.2 Янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төлөөлөх, хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх үндэсний зохицуулах механизмд ажиллаж буй гишүүдийн тоон харьцаа
- 2.3 Жендэрийн эрх тэгш байдал ба эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх асуудал хариуцсан үндэсний тогтолцоонд төлөөлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон харьцаа
- 2.4 Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын саналын нууцлалыг хадгалах үйл явц нь хүртээмжтэй нийслэл хотод буй сонгуулийн саналын байрны тоон харьцаа

Нэмэлт шалгуур үзүүлэлтүүд

- 2.5 Үндэсний түвшинд засгийн газрын танхимд ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон харьцаа
- 2.6 Дээд шүүхэд шүүгчээр ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон харьцаа
- 2.7 Янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй хэлбэрээр сонгуулийн үйл ажиллагааг явуулахыг сонгуулийн үндэсний байгууллагаас шаардсан хууль эрх зүй байгаа эсэх

Зорилго 3

Хүрээлэн буй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл болон харилцаа холбооны хүртээмжийг сайжруулах

13 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцоо бүхий нийгэмд өөрсдийн эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд хүрээлэн буй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл болон харилцаа холбооны хүртээмж нь нөхцлийг нь бүрдүүлж өгч байгаа юм. Хот, хөдөө болон алслагдсан газарт хүрч очиход хүртээмжтэй боловсронгуй тоног төхөөрөмж нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст төдийгүй нийгмийн бусад бүх гишүүдийн хувьд аюулгүй, хэрэглэхэд хялбар болж ирж байна. Хөндлөнгийн хяналт шалгалтыг ашиглах нь хүртээмжтэй байдлыг хангах чухал арга хэлбэр бөгөөд энэ нь төлөвлөлтийн үйл явц, хийц загвар, барилга байгууламж, засвар үйлчилгээ, мониторинг болон үнэлгээ гэх бүх л үе шатыг хамрах ёстой. Туслах төхөөрөмж болон холбогдох дэмжих үйлчилгээ нь мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралын бие даасан байдлын таатай орчинг бий болгож, хүний ёсоор нэр төртэй амьдрахад бас нэг урьдчилсан нөхцөл болох юм. Нөөц баялаг хомс нөхцөлд амьдарч буй хүмүүст туслах төхөөрөмжийн хүртээмжтэй байдлыг бий болгоход судалгаа, хөгжил дэвшил, үйлдвэрлэл, түгээлт болон засвар үйлчилгээг дэмжих хэрэгтэй.

Зорилт 3.А

Улсын нийслэл хот дахь нийтийн газарт очих хүрээлэн буй орчны хүртээмжийг нэмэгдүүлэх

Зорилго 3.Б

Нийтийн тээврийн хүртээмж болон ашиглах нөхцлийг сайжруулах

Зорилго 3.В

Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмж ба ашиглах нөхцлийг сайжруулах

Зорилго 3.Г

Зохих туслах төхөөрөмж болон бүтээгдэхүүн байхгүй ч уг төхөөрөмжийг хэрэглэх шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоог хоёр дахин бууруулах

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

- 3.1 Улсын нийслэл дэх хүртээмжтэй засгийн газрын байрнуудын тоон харьцаа
- 3.2 Хүртээмжтэй олон улсын онгоцны буудлуудын тооны харьцаа
- 3.3 Олон нийтийн телевизийн өдөр тутмын бичгэн тайлбар болон дохионы хэлний орчуулагатай мэдээллийн хөтөлбөрийн тоон харьцаа
- 3.4 Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүртээмжтэй стандарт бүхий нийтийн бичиг баримт болон цахим хуудасны хүртээмжтэй болон ашиглаж болохуйц тоон харьцаа
- 3.5 Туслах төхөөрөмж болон бүтээгдэхүүн шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон дээрх төхөөрөмжийг хэрэглэж буй хүмүүсийн тоон харьцаа

Нэмэлт шалгуур үзүүлэлтүүд

- 3.6 Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар мэргэшсэн мэргэжилтний оролцоог шаардсан засгийн газрын аудитын програм байгаа эсэх
 - 3.7 Нийтийн хэрэглэх байшин барилгын бүх хийц загварын зөвшөөрлийг тодорхойлох саадгүй нэвтрэх заавал дагаж мөрдөх техникийн стандарт буюу Олон улсын Стандартын Байгууллага (ISO)-ын стандарт зэрэг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд байгаа эсэх
 - 3.8 Дохионы хэлний орчуулагчийн тоо
 - 3.9 Мэдээлэл харилцаа технологийн холбогдох бүх үйлчилгээ, тухайлан нийтийн цахим хуудас гэх үйлчилгээний зөвшөөрлийг тодорхойлох саадгүй нэвтрэх заавал дагаж мөрдөх техникийн стандарт буюу Олон улсын Стандартын Байгууллага (ISO)-ын стандарт зэрэг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд байгаа эсэх
-

Зорилго 4

Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх

14 Ази болон Номхон Далайн бүс нутгийн хөгжиж буй улс орнууд нийгмийн хамгааллыг ихэнх тохиолдолд нийгмийн даатгалын хөтөлбөрөөр хязгаарлаж, албан секторт тогтмол хөдөлмөрийн гэрээтэй хүмүүст зөвхөн хүртээмжтэй байдаг бөгөөд хүн амын үлдсэн дийлэнх хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үүнд хамруулахгүй орхиж байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил ижил тэгш байдлаар нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртэх байдлыг хангах нь чухал бөгөөд цаашлаад бүх хүнд эрүүл мэндийн үйлчилгээ, үндсэн орлогын хамгаалал дээр тулгуурласан нийгмийн хамгааллын бодлогыг хөхиүлэн дэмжих нь чухал байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тухайн нийгэмд бие даан амьдрах боломжийг бий болгох хувийн туслах болон зөвлөлгөө өгөх зэрэг боломжийн үйлчилгээнүүд хомс байна. Хөгжлийн бэрхшээлтэй ихэнх хүмүүст эдгээр төрлийн үйлчилгээ нь тэднийг нийгэмд оролцоход зайлшгүй шаардлагатай болж байгаа юм.

Зорилт 4.А

Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст нөхөн сэргээх үйлчилгээ зэрэг эрүүл мэндийн бүх төрлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

Зорилго 4.Б

Нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хамрагдалтыг нэмэгдүүлэх

Зорилго 4.В

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялангуяа янз бүрийн, өргөн хэмжээний, олон талт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тухайн нийгэмд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх хувийн туслах үйлчилгээ болон зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ, хөтөлбөрийг сайжруулах

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

- 4.1 Засгийн газрын дэмжлэгтэй эрүүл мэндийн халамжийн хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоог үндсэн хүн амтай харьцуулах
- 4.2 Нийгмийн даатгал болон нийгмийн тусламж дэмжлэгийн хөтөлбөр гэх нийгмийн хамгааллын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хамрагдсан байдал
- 4.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд бие даан амьдрах боломж олгох хувийн туслах үйлчилгээ болон зөвлөх үйлчилгээ зэрэг засгийн газрын тэтгэлэгтэй үйлчилгээ, хөтөлбөр байгаа эсэх

Нэмэлт шалгуур үзүүлэлтүүд

- 4.4 Түр халамж зэрэг засгийн газрын дэмжлэгтэй халамжийн үйлчилгээний хөтөлбөрийн тоо
 - 4.5 Хамт олонд суурилсан үндэсний нөхөн сэргээх хөтөлбөр байгаа эсэх
 - 4.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан эрүүл мэндийн даатгал байгаа эсэх
 - 4.7 Тусламж, дэмжлэгийн үйлчилгээний шаардлага буурсан байдал
-

Зорилго 5

Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүд болон тэдний гэр бүлийг дэмжих тогтолцоо болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролыг өргөжүүлэх

15 Хүүхдүүдийн дунд хөгжлийн бэрхшээл болон хөгжлийн хоцрогдлын асуудлыг нилээдгүй орхигдуулж байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн ихэнх нь ядуу гэр бүлд амьдарч байна. Ази болон Номхон Далайн ихэнх бүс нутагт хөгжлийн бэрхшээлтэй аль эсвэл хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүд болон тэдний гэр бүлийг дэмжих тогтолцоо болон боловсролын хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн тоо харьцангуй байна. Хөгжлийн чухал үед хүрэхэд хөгжлийн хоцрогдолтыг эртнээс илрүүлэх нь нярай болон хүүхдийн өндөр, жинг тогтмол үзэхтэй адил чухал юм. Хөгжлийн хоцрогдолтыг эртнээс илрүүлэхэд тэдний бүхий л өсөлт хөгжилтийг сайжруулахад түргэн шуурхай, тохиромжтой арга хэмжээ авах нь чухал юм. Хөгжлийн бэрхшээлтэй аль эсвэл хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүд болон тэдний гэр бүлийг эртнээс дэмжих ийм төрлийн тогтолцоонд урамшуулал үзүүлэх, хүмүүжүүлж, анхаарч халамжилах мөн сургуулийн өмнөх боловсрол зэрэг орно. Бага насны хүүхдэд зориулсан хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх нь дараагийн шатны боловсрол, сургалтаас илүү үр өгөөжтэй. Засгийн газраас бага насны хүүхдийн хөтөлбөрт чиглэсэн арга хэмжээ авч үүргээ биелүүлэх нь тухайн улсын хөгжлийн үр дүнг мэдэгдэхүйц сайжруулна. Түүнчлэн засгийн газрын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдийн адил чанартай анхан шатны болон дунд шатны боловсрол эрх тэгш хүртэх явдлыг хангах нь чухал ач холбогдолтой юм. Үүний тулд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг илүү үр дүнтэйгээр дэмжихэд тэдний гэр бүлийг нь оролцуулан хамтран ажиллах явдал юм.

Зорилт 5. А

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг төрөхөөс нь эхлэн сургуулийн өмнөх нас хүртэл тэд болон тэдний гэр бүлийг нь дэмжих тогтолцоог болон хөгжлийн бэрхшээл аль эсвэл хөгжлийн хоцрогдолтыг эртнээс илрүүлэх арга хэмжээг сайжруулах

Зорилт 5. Б

Анхан шатны болон дунд шатны сургуульд бүртгүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдийн хоорондын тоон ялгааг хоёр дахин бууруулах

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

5.1 Хөгжлийн бэрхшээлтэй аль эсвэл хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүд болон тэдний гэр бүлийг дэмжих тогтолцоонд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо

5.2 Анхан шатны боловсрол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн элсэлтийн тоо

5.3 Дунд шатны боловсрол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн элсэлтийн тоо

Нэмэлт шалгуур үзүүлэлтүүд

5.4 Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт тогтоох болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн талаарх мэдээлэл, үйлчилгээгээр хангадаг төрөхийн өмнөх болон хүүхэд хэвлийд байх үед эхчүүдэд халамж үйлчилгээ үзүүлдэг газруудын тоон харьцаа

5.5 Дохионы хэлний сургалт авч буй хөгжлийн бэрхшээлтэй дүлий хүүхдүүдийн тоон харьцаа

5.6 Уншиж болохуйц хэлбэрт оруулсан сургалтын материалыг хэрэглэж буй харааны бэрхшээлтэй сурагчдын тоон харьцаа

5.7 Туслах төхөөрөмж, тохирох сургалтын хөтөлбөр, зохих сургалтын материалтай оюуны бэрхшээлтэй, хөгжлийн бэрхшээлтэй, сонсгол харааны бэрхшээлтэй, аутизмтай болон бусад хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын тоон харьцаа

Зорилго 6

Жендэрийн эрх тэгш байдал болон эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх явдлыг хангах

16 Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүд нь янз бүрийн ялгаварлан гадуурхалт болон хүчирхийлэлд өртдөг. Тусгаарлагдмал байдал болон асрагчаасаа хараат байх явдал нь эдгээр хүмүүсийг янз бүрийн хэлбэрийн мөлжлөгө, хүчирхийлэл, доромжлолд өртөмтгий болгодог бөгөөд үүнийг дагаад ХДХВ-ын халдвар, жирэмслэлт, эхийн болон нярайн эндэгдэл зэрэг эрсдлийг бий болгодог байна. Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүд нь жендэрийн эрх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих хөтөлбөрт хамрагдадгүй байна. Бэлгийн болон

нөхөн үржихүйн эрүүл мэнд, ерөнхий эрүүл мэндийн болон холбогдох үйлчилгээний талаарх мэдээлэл нь хүртээмжтэй байдлаар түгээгдэх нь ховор байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүд нь хөгжлийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцогч болсон үед л 10 жилийн хөтөлбөрийн жинхэнэ амлалт бүрэн дүүрэн хэрэгжих юм.

Зорилт 6. А

Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдэд зонхилох хөгжлийн боломж бололцоог ижил тэгш хүртэх явдлыг бий болгох

Зорилт 6. Б

Засгийн газрын шийдвэр гаргах бүхий байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн төлөөллийг бий болгох явдлыг хангах

Зорилт 6. В

Хөгжлийн бэрхшээлтэй бүх охид эмэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлгүй охид эмэгтэйчүүдийн нэгэн адил бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг хүртэх явдлыг хангах

Зорилт 6. Г

Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, доромжлолоос хамгаалах арга хэмжээг нэмэгдүүлэх

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

6.1 Жендэрийн эрх тэгш байдал ба эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх үндэсний хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын оролцоог хөхиүлэн дэмжих явдлыг тусгасан улс орны тоо

6.2 Парламентад аль эсвэл үүнтэй адил тухайн улсын хууль тогтоох байгууллагад эзэлж буй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тоон харьцаа

6.3 Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагын бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн

бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн тоог хөгжлийн бэрхшээлгүй охид эмэгтэйчүүдийн тоотой харьцуулах

6.4 Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг зэрэг аливаа хүчирхийллийг устгахад чиглэсэн засгийн газар болон холбогдох агентлагын санаачилсан хөтөлбөрийн тоо

6.5 Аливаа хэлбэрийн хүчирхийллийн хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд охидод зориулсан нөхөн сэргээх эмчилгээ зэрэг засгийн газар болон холбогдох агентлагын санаачилсан халамж, дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн тоо

Зорилго 7

Гамшгийн эрсдлийг бууруулах болон менежментэд хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангах

17 Ази болон Номхон Далайн бүс нутаг нь цаг агаарын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг зэрэг гамшигт хамгийн ихээр өртдөг бүс нутаг билээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад эмзэг бүлэгт буй хүмүүс нь амь алдах, гэмтэл бэртэл болон бусад согогтой болох өндөр эрсдэлд байгаа нь тэднийг гамшгийн аюулыг бууруулахад чиглэсэн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрт хамруулаагүйгээс үүдэлтэй юм. Олон нийтэд зориулсан үйлчилгээний зарлал нь ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй байдлаар гардаг байна. Түүнчлэн аюулын гарц, хорогдох байр болон техник хэрэгсэл нь ихэвчлэн хэрэглэхэд саад бэрхшээлтэй байдаг байна. Орон нутгийн болон дүүргийн хэмжээнд явагдах онцгой байдалд урьдчилан сэргийлэх сургуулилт болон гамшгийн эрсдлийг бууруулах бусад арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тогтмол оролцуулснаар гамшгийн үед гарах аливаа эрсдэл, хохиролоос урьдчилан сэргийлэх буюу бууруулах боломжтой юм. Боловсронгуй хэлбэр хийцийн зарчмыг оруулсан биет болон мэдээллийн дэд бүтэц нь аюулгүй байдал болон амь гарах боломжийг нэмэгдүүлж өгнө.

Зорилт 7. А

Хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан гамшгийн эрсдлийг бууруулах төлөвлөгөөг бэхжүүлэх

Зорилт 7. Б

Гамшгийн асуудлаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст цаг хугацаанд нь зохих дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг бэхжүүлэх

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

7.1 Хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө байгаа эсэх

7.2 Холбогдох бүх үйлчилгээний ажилтнуудад зориулсан хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан сургалт байгаа эсэх

7.3 Онцгой байдлын үед хорогдох байр болон гамшгаас хамгаалах байрны хүртээмжтэй байдлын тоон харьцаа

Нэмэлт шалгуур үзүүлэлтүүд

7.4 Гамшгийн улмаас нас барсан болон ноцтой бэртсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо

7.5 Гамшигт нэрвэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж үзүүлэх чадвартай, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүний нөөц байгаа эсэх

7.6 Гамшигт бэлдэх болон гамшгийн үед авах арга хэмжээний үед ашиглах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан туслах тоног төхөөрөмж, технологи байгаа эсэх

Зорилго 8

Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийн сангийн үнэн бодит байдал болон харьцуулсан тоо баримтыг сайжруулах

18 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь үзэгдэж харагдахгүй, сонсогдохгүй, мөн тооллогонд орохгүй хандлагатай байдаг. Ялангуяа сүүлийн жилүүдэд эдгээр хүмүүс тооллогод орох болсноор хөгжлийн бэрхшээлийн талаарх тоо баримтыг цуглуулахад “хөгжлийн бэрхшээл” болон “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс” гэсэн тодорхойлолтыг Ази-Номхон Далайн бүс нутагт янз бүрээр өргөн хүрээнд хэрэглэж байна. Ерөнхийдөө улс орнуудын дунд хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн талаарх тоо баримтын харьцуулалт нь ихэнхдээ эргэлзээтэй гардаг. Ази-Номхон Далайн бүс нутгийн хувьд хүн янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүн ам болон тэдний нийгэм-эдийн засгийн төлөв байдлын талаарх илүү нарийн тоо баримт шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлийн талаарх статистикий тоо мэдээ үнэн зөв байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хэрэгжүүлэхэд баримтад тулгуурласан бодлого боловсруулах боломжийг бүрдүүлж өгнө. 10 жилийн хөтөлбөр нь цаг хугацааны туршид болон улс орнуудын дунд хөгжлийн бэрхшээлийн талаарх харьцуулсан статистик тоо баримтыг бий болгоход чиглэсэн мэдээллийн санг сайжруулах боломж юм. Инчоны стратегийн шалгуур үзүүлэлтүүдэд зориулсан үндсэн тоо баримтыг бэлэн болгох нь маш ач холбогдолтой бөгөөд энэ нь стратегийн зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн ахиц дэвшлийг үр дүнтэйгээр шалгах явдлыг бий болгох юм.

Зорилт 8. А

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй хэлбэрээр үнэн бодит, олон улсын хэмжээнд харьцуулж болох хөгжлийн бэрхшээлийн талаарх статистик тоо баримтыг гаргаж, түгээх

Зорилт 8. Б

10 жилийн хөтөлбөрийн дунд үе буюу 2017 онд Инчоны стратегийн зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн ахиц дэвшлийг шалгахад эх сурвалж болох хөгжлийн бэрхшээлийн талаарх үнэн бодит статистик тоо баримт гаргах

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

8.1 Нас, хүйс, арьс өнгө болон нийгэм-эдийн засгийн байдлаар нь Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн асуудлаарх олон улсын ангилалд (ICF) тулгуурлаж хөгжлийн бэрхшээлийн тархалтыг гаргах

8.2 Инчоны стратегийн зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн ахиц дэвшлийг шалгахад ашиглах үндсэн тоо баримтыг 2017 он гэхэд гаргасан Ази-Номхон Далайн бүс нутаг дах засгийн газруудын тоо

8.3 Зонхилох хөгжлийн хөтөлбөр болон засгийн газрын үйлчилгээ, тухайлан эрүүл мэнд, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөр гэх үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд охидын талаарх салангид гаргасан тоо мэдээ байгаа эсэх

Зорилго 9

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг соёрхон батлуулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, үндэсний хууль тогтоомжийг Конвенцтой нийцүүлэх

19 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах цогц арга замыг тусгасан, хөгжлийн бэрхшээлийг тусгайлан авч үзсэн анхны олон улсын хууль тогтоомж юм. Тус конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх эдлэгч гэдэг үүднээс эрх мэдэлжүүлсэн бөгөөд тэднийг зөвхөн халамж авдаг объект гэдгээс салгаж өгсөн. Тус конвенцийг санаачилж, боловсруулахад АНДБЭЗНК-ын бүс нутаг гол нөлөөллийн болон түүхэн үүрэг гүйцэтгэжээ. 2012 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар, 126 улс конвенцид нэгдэн орж, 154 улс гарын үсэг зуржээ. Үүнээс Ази-Номхон Далайн бүс нутгийн 35 улс гарын үсэг зурж, 25 улс уг конвенцийг соёрхон батласан буюу нэгдэн оржээ.

Зорилт 9. А

10 жилийн хөтөлбөрийн дунд үе (2017) гэхэд Ази-Номхон Далайн бүс нутгийн дахиад 10 улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг соёрхон батлах буюу нэгдэн орсон байх бөгөөд 10 жилийн хөтөлбөрийн төгсгөл үед (2022) Ази-Номхон Далайн бүс нутгийн өөр бас 10 засгийн газар уг конвенцийг соёрхон батлах буюу нэгдэн орсон байх болно

Зорилт 9. Б

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг дэмжих, хамгаалах үүднээс ялгаварлан гадуурхалтын эсрэг заалт болон техникийн стандарт норм болон бусад арга замыг тусгасан үндэсний хууль

тогтоомжийг батлаж гаргах, мөн үндэсний хууль тогтоомжийг Конвенцтой нийцүүлэх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шууд болон шууд бус байдлаар ялгаварлан гадуурхсан үндэсний хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах аль эсвэл хүчингүй болгох

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

9. 1 Конвенцийг соёрхон батласан буюу нэгдэн орсон засгийн газруудын тоо

9. 2 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг дэмжих, хамгаалах бүхий ялгаварлан гадуурхалтын эсрэг үндэсний хууль тогтоомж байгаа эсэх

Нэмэлт шалгуур үзүүлэлтүүд

9. 3 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн Нэмэлт Протоколыг батласан Ази-Номхон Далайн бүс нутгийн засгийн газруудын тоо

9. 4 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шууд болон шууд бус байдлаар ялгаварлан гадуурхсан хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулсан тоо буюу хүчингүй болгосон хууль тогтоомжийн тоо

Зорилго 10

Дэд бүс нутгийн, бүс нутаг болон бүс нутаг хоорондын хамтын ажиллагааг сайжруулах

20 Сургамж болон сайн туршлага, шинэ санаачлага шийдвэрээ хуваалцах замаар харилцан бие биенээ дэмжихэд дэд бүсийн, бүс нутаг дахь болон бүс нутаг хоорондын хамтын ажиллагаа маш чухал болохыг Ази болон Номхон Далайн бүс нутгийн 10 жилийн 2 хөтөлбөрийн туршлагаар батлагдсан. Үр дүнтэй тусламжийн асуудлаарх дээд хэмжээний 4 дэх удаагийн чуулганаар 2011 оны 12 сарын 1-нд батлагдсан (Пусан, Солонгос улс) Үр дүнтэй хөгжлийн хамтын ажиллагааны тухай Пусаны Түншлэлээр¹⁴ үр дүнтэй хөгжлийн төлөөх хамтын ажиллагааны суурийг тавихад хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх олон

¹⁴ www.Aideffectiveness.org/busanhlf4/images/stories/hlf4/OUTCOME_DOCUMENT_-_FINAL_EN.pdf. -ыг хар

улсын үүрэг амлалт чухал болохыг хүлээн зөвшөөрсөн. Иргэний нийгэм болон хувийн салбар нь Инчоны зорилго, зорилтод хүргэх шинэ хандлага, арга замыг хөдөлгөхөд чухал үүрэг гүйцэтгэж чадна. Ази-Номхон Далайн бүс нутаг нь одоо хүртэл урт хугацааны сорилттой тулгарсаар байгаа. Зөрчилт мөргөлдөөн болж өнгөрсөн газар нутагт газрын мина болон дайны ул мөр зэрэг сорилтууд нь хөгжлийн бэрхшээл бий болгоход нөлөөлж, хүмүүсийн амьжиргааг дордуулсаар байна. Эдгээр сорилтыг даван туулж, үр дүнтэй хэрэгжилтийг дэмжих үүднээс 10 жилийн хөтөлбөр нь олон талт салбарын хүрээтэйгээр олон улсын хамтын ажиллагаа бий болгох бололцоог хангаж байгаа юм.

Зорилт 10. А

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн талаарх Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор АНДБЭЗНК-ын удирдаж буй Ази-Номхон Далайн бүс нутгийн Олон талт-донорын итгэлцлийн фонд болон бусад санал санаачлага, хөтөлбөрт хувь нэмэр оруулах

Зорилт 10. Б

Ази-Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн хамтын ажиллагааны агентлагууд өөрсдийн бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн оролцоог бэхжүүлэх

Зорилт 10. В

НҮБ-ын бүс нутгийн комиссууд нь хөгжлийн бэрхшээлийн тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн асуудлаар бүс нутаг хоорондын туршлага солилцох явдлыг бэхжүүлэх.

.....

Ахиц дэвшлийг шалгах шалгуур үзүүлэлтүүд

Гол шалгуур үзүүлэлтүүд

10.1 Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн талаарх Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг дэмжих Ази-Номхон

Далайн бүс нутгийн олон-талт итгэлцлийн фондод засгийн газрууд болон бусад донороос жил бүр сайн дурын хандив оруулж байгаа эсэх

10.2 Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн талаарх Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг дэмжих Ази-Номхон Далайн бүс нутгийн олон-талт итгэлцлийн фондод жил бүр хандив оруулж буй донорын тоо

10.3 Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн талаарх Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг дэмжихэд санал санаачлага болон хөтөлбөрт Засгийн газрууд болон бусад донороос жил бүр сайн дурын хандив оруулж байгаа эсэх

10.4 Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн талаарх Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг шууд дэмжих Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаа зэрэг бүс нутгийн хамтын ажиллагааны хөтөлбөртэй НҮБ-ын байгууллагын тоо

10.5 Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн талаарх Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг дэмжих Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаа зэрэг хөтөлбөртэй дэд бүсийн засгийн газар хоорондын байгууллагуудын тоо

10.6 Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн талаарх Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг дэмжихэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийг дэмжих байгууллага оролцсон Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаа зэрэг бүс нутгийн болон дэд бүсийн төсөл хөтөлбөрийн тоо

10.7 Ази болон Номхон Далайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжлийн асуудлаар ажиллах чиг үүрэг, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө болон энэ асуудлаар мэргэшсэн мэргэжилтэнтэй мөн Конвенцийг соёрхон батлах, хэрэгжүүлэх асуудлыг дэмжиж, цаашид авах арга хэмжээнд хяналт тавьдаг хөгжлийн хамтын ажиллагааны агентлагуудын тоо

10.8 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн НҮБ-ын бүс нутгийн 5 комиссийн дунд явуулсан хамтарсан үйл ажиллагааны тоо

10.9 АНДБЭЗНК болон бусад холбогдох агентлагуудын явуулсан хөгжлийн бэрхшээлийн талаарх статистик, ялангуяа Үйл ажиллагаа, хөгжлийн

бэрхшээл болон эрүүл мэндийн асуудлаарх олон улсын ангилал (ICF)-ын хандлагын талаарх сургалтанд хамрагдсан Ази-Номхон Далайн бүс нутаг дахь статистикийн мэргэжилтнүүдийн тоо

10.10 Тухайн улсын түвшин дэх НҮБ-ын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлыг оруулах асуудлыг тусгасан НҮБ-ын Хөгжлийн Багийн удирдамжтай нийцсэн хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжлийг авч хэлэлцэхээр оруулсан НҮБ-ын улс орон болон бүс нутгийн түвшний хөгжлийн тусламжийн баримт бичгийн тоо

Г. Үр дүнтэй хэрэгжилтийг бий болгох арга замууд: үндэсний, дэд бүсийн болон бүсийн түвшинд

21 Энэхүү хэсэг нь хэрэгжилтийг дэмжих, хөхиүлэн дэмжих арга замыг тодорхойлно. Ялангуяа эдгээр арга зам нь 10 жилийн хөтөлбөрийн явцад Инчоны стратегийг хэрэгжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дэвшилд хүрэхийн тулд тоо баримт болон мэдээллийг бүрдүүлж, олон талт түвшний хамтын ажиллагааг бэхжүүлэх юм.

1. Үндэсний түвшинд

22 Инчоны стратегийн хэрэгжилтийн амин зүйл нь үндэсний түвшний бүх чухал харилцаа холбоо бүхий хөгжлийн бэрхшээлийн талаарх үндэсний зохицуулах механизм болно.

23 Ийм төрлийн олон механизм нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жилийн сүүлийн хоёр хөтөлбөрийн явцад бий болсон. Тиймээс эдгээр механизм нь Инчоны стратегийн хэрэгжилтийг үндэсний түвшинд зохицуулах болон хөдөлгөх анхан шатны үүрэг хариуцлагыг өөр дээрээ авах юм.

24 Үндэсний зохицуулах механизмын дор үндэсний статистикийн байгууллагууд нь Инчоны стратегийн хэрэгжилтийн ахиц дэвшлийг шалгах болон хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэд хэрэг болох үндсэн тоо баримтыг бүрдүүлэх, энэ асуудлыг хариуцах гол үүргийг гүйцэтгэх болно.

25 Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан үндэсний зохицуулах механизм нь дараах үүрэг даалгаврыг гүйцэтгэх ёстой ч үүгээр хязгаарлагдахгүй:

а Инчоны стратегийг хэрэгжүүлэхэд олон салбарын яамд, газар агентлагууд болон засгийн газрын бүх шатны байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд тухайлан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийг дэмжих байгууллага, тэдний гэр бүлийг дэмжих баг, судалгааны

хүрээлэнгүүд болон хувийн хэвшил гэх олон талт салбарыг үндэсний өргөн хэмжээнд оролцуулан дайчлах;

б Инчоны стратегийн зорилго, зорилтод хүрэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийн талаар мониторинг хийж, тайлагнах;

в Инчоны стратегийг тухайн улс өөрийн эх хэл рүү орчуулж, бүх салбар болон засаг захиргааны бүх түвшинд өргөнөөр түгээхийн тулд хүртээмжтэй хэлбэрээр эх хэл дээрх хувийг гаргах;

г Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх эерэг хандлагыг дэлгэрүүлж буй 10 жилийн хөтөлбөрөөр дамжуулан, хүмүүсийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд “ Эрхийг нь бодитой болгох аян” зэрэг үндэсний аянг зохион байгуулах;

д Бодлого боловсруулах үндэс суурийг тавихын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдлын талаарх судалгааг урамшуулан, хөхиүлэн дэмжих.

26 Тухайн улсад ажиллаж буй НҮБ-ын байгууллага нь үндэсний зохицуулах механизмыг эрчимжүүлэх болон тэдний үйл ажиллагааг дэмжих шаардлагатай бөгөөд ялангуяа хэрэгжилтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа, зохицуулалт болон хамтын ажиллагааг илүү ихээр анхаарч дэмжих шаардлагатай болно.

2. Дэд бүсийн түвшинд

27 Дэд бүсийн засгийн газар хоорондын аж ахуйн нэгж болох Зүүн-Өмнөд Азийн улсуудын холбоо, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Бүсийн хамтын ажиллагааны Номхон Далайн арлуудын чуулган болон Өмнөд Азийн холбоо нь өөрсдийн чиг үүргийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан бодлого, хөтөлбөрийг идэвхитэй хөхиүлэн дэмжих замаар Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ.

28 АНДБЭЗНК-ын Нарийн бичгийн газар нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийг хөхиүлэн дэмжихэд, дэд бүсийн засгийн газар хоорондын байгууллагуудтай хамтран дэд бүсийн болон дэд бүсийн хоорондын хамтын ажиллагааг дэмжих ёстой. Ингэснээр, хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжлийг хөхиүлэн дэмжихэд бүс нутгийн байгууллагуудын¹⁵

¹⁵ Солонгос улсын Инчон хот дахь Хөгжлийн төлөөх мэдээлэл, харилцаа холбоо, технологийн Ази болон Номхон Далайн бүс нутгийн сургалтын төв (APCICT); Шинэ Дели дэх Ази болон Номхон далайн бүс нутаг дахь технологийг шилжүүлэх төв (APCTT); Токио хот дахь Ази болон Номхон Далайн бүс нутгийн статистикийн хүрээлэн (SIAP); Индонези улсын Богор хот дахь Тогтвортой хөдөө аж ахуйгаар дамжуулан ядуурлыг бууруулах төв (CAPSA); Бээжин дэх Хөдөө

дэмжлэгийг авдаг Хойд болон Төв Ази, Зүүн болон Зүүн-Хойд Ази, Номхон Далайн бүс нутаг, Өмнөд болон Баруун-Өмнөд Ази дахь өөрийн салбар байгууллагуудын идэвхтэй оролцоог ашиглах болно.

3. Бүс нутгийн түвшинд

29 АНДБЭЗНК-ын гишүүн болон сурвалжлагч гишүүн орнууд нь Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийг хэрэгжүүлэхэд гарч буй ахиц дэвшил, сорилт бэрхшээл, сайн туршлагын талаар Нийгмийн хөгжлийн Хороо буюу үүнтэй ижил төстэй хорооны байнгын уулзалтаар харилцан санал солилцож, хэлэлцэх хэрэгтэй. Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид дээрх уулзалтанд оролцох явдлыг дэмжих болно.

30 Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн бүс нутгийн ажлын хэсгийг байгуулах ёстой. Ажлын хэсэг нь 10 жилийн хөтөлбөрийн турш хөтөлбөрийг бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх явдлыг дэмжих ёстой. Ажлын хэсгийн үйл ажиллагаа нь Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийг бүс нутагт хэрэгжүүлэх талаар гишүүн болон сурвалжлагч гишүүн орнуудад зөвлөмж, дэмжлэг үзүүлэхэд чиглэх юм. Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтанд тусгасан болно.

31 АНДБЭЗНК-ын Нарийн бичгийн газар нь өөрийн бүс нутаг дахь гүйцэтгэх үүрэг, дүн шинжилгээний ажил болон засгийн газруудад техникийн дэмжлэг үзүүлэх замаар Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах хэрэгтэй. Ялангуяа НҮБ-ын байгууллагуудтай хамтран дараах арга хэмжээг авах ёстой:

а Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцтой үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх болон “Эрхийг нь бодитой болгох” аяныг хөхиүлэн дэмжих тал дээр засгийн газруудад дэмжлэг үзүүлэх;

б Гишүүн болон сурвалжлагч гишүүн орнуудын дунд хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжил болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, хангах асуудлаарх үндэсний сайн дадлага, туршлагыг хуваалцах явдлыг хөхиүлэн дэмжих, тухайлан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хөхиүлэн дэмжихийн тулд үндэсний хууль тогтоомж болон захиргааны байгууллагуудын талаар авч хэрэгжүүлсэн сайн туршлагын хуваалцах;

в 10 жилийн хөтөлбөрийн явцад хөгжлийн бэрхшээлийн талаарх статистик тоо баримтыг боловсронгуй болгох явдлыг дэмжиж, ахиц дэвшлийг нь шалгах;

аж ахуйн инженер болон машин механизмын НҮБ-ын Ази болон Номхон Далайн бүс нутгийн төв (UNAPCAEM).

г Хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан хөгжлийг хөхиүлэн дэмжихийн тулд гишүүн болон сурвалжлагч гишүүн орнуудын чадавхийг бий болгох явдлыг дэмжих;

д Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийг дэмжих байгууллагыг татан оролцуулах, мөн холбогдох талуудын бүсийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах.

32 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлэх, тэдгээр хүмүүсийн төлөөлөл байгууллага, саад бэрхшээлгүй, оролцооны нийгмийг хөхиүлэн дэмжих зорилгоор байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх Ази-Номхон Далайн бүс нутгийн хөгжлийн төв нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жилийн хөтөлбөрийн анхны өв хөрөнгө болж байгуулагдсан юм. Энэхүү төвөөс хөгжлийн бэрхшээлд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, ажлын байр болон дадлага хийх хөгжлийг дэмжсэн буюу хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангасан бизнест хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцохыг уриалах тал дээр голлон анхаарч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадавхийг бий болгох болон олон талт салбарын хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэхийг хүсчээ.

33 Солонгос улсад байрлах “Эрхийг нь бодитой болгох” Санг тус улс санаачлан байгуулсан бөгөөд тус сан нь Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн талаарх Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийг амжилттай хэрэгжүүлэх явдлыг дэмжиж байна.

34 Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийг дэмжих байгууллагуудыг Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийг хэрэгжүүлэхэд оролцохыг мөн 10 жилийн хөтөлбөрийн туршид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүсэл эрмэлзэл, тэдний хэрэгцээ шаардлагын дагуу тогтмол арга хэмжээ авахыг уриалж байна.

Хавсралт

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жилийн хөтөлбөрийн Ажлын хэсгийн удирдамж

Зорилго

1. Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жилийн хөтөлбөрийн асуудал хариуцсан бүс нутгийн Ажлын хэсгийн зорилт нь 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийг бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжилтийг хөхиүлэн дэмжихэд гишүүн болон сурвалжлагч гишүүн орнуудад техникийн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх юм.

Чиг үүрэг

2. Дээрх өгүүлбэрт зорилтыг тодорхойлсны дагуу, Ажлын хэсэг нь дараах асуудлаар гишүүн болон сурвалжлагч гишүүн орнуудад зөвлөгөө өгнө:
 - а 10 жилийн хөтөлбөрийн дэвшилтэй танилцах буюу ялангуяа Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн талаарх Сайд нарын Тунхаглал болон Ази-Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчоны стратегийн хэрэгжилтийн явцыг хянах;
 - б Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх бүс нутгийн болон дэд бүсийн хамтын ажиллагааны талаар;
 - в Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдлын талаарх судалгааны талаар;
 - г Үндэсний болон орон нутгийн түвшинд янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрч ажиллах болон хэлхээ холбоо байгуулах талаар.

Гишүүнчлэл

3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь АНДБЭЗНК-ын гишүүн болон сурвалжлагч гишүүн орны төлөөлөл мөн Ази болон Номхон Далайн бүс нутагт бүсийн болон дэд бүсийн түвшинд үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагаас бүрдэх болно.
4. Ажлын хэсгийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байх бөгөөд энэ нь дахин 5 жилээр сунгагдах боломжтой.
5. АНДБЭЗНК-ын бүх гишүүн болон сурвалжлагч гишүүд нь ажлын хэсэгт ажиллаж болно.
6. Ажлын хэсэг нь 30 гишүүнтэй байх бөгөөд ингэхдээ жендэрийн тэгш байдлыг харгалзан үзнэ. Үүнээс 15 гишүүн нь АНДБЭЗНК-ын гишүүн болон сурвалжлагч гишүүн орноос, 15 гишүүн нь иргэний нийгмийн байгууллагаас орно. Иргэний нийгмийн байгууллагад зориулсан суудлын талаас доошгүй суудал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон шинээр гарч ирж буй иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд зориулна.
7. Дараах шалгуурыг хангасан иргэний нийгмийн байгууллага ын Ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж болно. Үүнд: (а) Ази болон Номхон Далайн бүс нутагт бүсийн буюу дэд бүсийн түвшинд ажилладаг; (б) янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ашиг сонирхлыг хөхиүлэн дэмждэг буюу тусалж дэмждэг аль эсвэл тэднийг төлөөлдөг байгууллага аль эсвэл сүлжээ байх; (в) Сайд нарын Тунхаглал болон Инчоны стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд хэрэгтэй техникийн мэргэшил чадвартай байх.
8. Солонгос улсын Инчон хотод 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 11 дүгээр сарын 2-ны өдрүүдэд болох Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2003-2012 оны 10 жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх Засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтын үеэр сонирхсон бие даасан АНДБЭЗНК-ын гишүүн болон сурвалжлагч гишүүн орнууд болон иргэний нийгмийн байгууллагууд нь Ажлын хэсэгт ажиллах тухай зарлалыг хийнэ.
9. Дээр дурдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг эцэслэн шийдвэрлүүлэхээр Засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтын өмнөх чуулганы үеэр Комисс руу тус бүрэлдэхүүний жагсаалтыг хүргүүлэх ёстой. Ийнхүү 2013 онд болох Комиссын 69 дүгээр чуулга уулзалт дээр эхний томилгоо буюу 2013-2017 он хүртэл ажиллах Ажлын хэсгийн бүрэлдэхүүний томилгооны эцсийн шийдвэр гарна. Ажлын хэсэгт ажиллах тухай 2 дахь зарлалыг 10 жилийн хөтөлбөрийн (2017) дунд үе шатыг тохиолдуулан хийх Засгийн газар хоорондын дээд хэмжээний уулзалтын үеэр хийнэ. 2018 онд болох Комиссын 74 дүгээр чуулга уулзалт дээр 2 дахь томилгоо буюу 2018-2022 он хүртэл ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүний томилгооны эцсийн шийдвэр гарна.

10. АНДБЭЗНК-ын гишүүн болон сурвалжлагч гишүүн, иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд, дэд бүсийн засгийн газар хоорондын агентлагууд, НҮБ-ын агентлагууд, хөгжлийн хамтын ажиллагааны агентлагууд болон хөгжлийн банкууд нь Ажлын хэсгийн уулзалтанд ажиглагчийн хувиар оролцож болно.

Үйл ажиллагааны дотоод журам

11. Ажлын хэсэг нь өөрийн үйл ажиллагааны дотоод журмыг батлах ёстой.

Ажлын алба

12. АНДБЭЗНК-ын Хэрэг эрхлэх газар нь Ажлын хэсгийн ажлын албаны үүрэг гүйцэтгэнэ. Тус ажлын алба нь Ажлын хэсгийн баримт бичгийг хүртээмжтэй хэлбэрээр түгээх ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь:

Хүмүүст харагдаж байх эрхтэй	Дуу хоолойгоо хүргэж байх эрхтэй	Тооллогонд хамрагдаж байх эрхтэй
---	---	---

Ази болон Номхон Далайн бүс нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох”-ын тулд Инчоны стратегийг дэмжицгээе!

Газрын зураг дээр хараар тэмдэглэсэн хэсэг нь АНДБЭЗНК-ын гишүүн болон сурвалжлагч гишүүн орнууд болно.

АНДБЭЗНК-ын хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, дараах хаягаар холбоо барина уу:

Director - Дарга

Social Development Division – Нийгмийн Хөгжлийн Хэлтэс

Economic and Social Commission for Asia and the Pacific (ESCAP) – Ази болон Номхон Далайн Бүсийг хариуцсан Эдийн Засаг, Нийгмийн Комисс /АНДБЭЗНК/

United Nations Building – Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байр

Rajadamnern Nok Avenue – Ражадамнерн Нок Гудамж

Bangkok 10200, Thailand – Бангкок 10200, Тайланд

Tel: (66-2) 288-1513, Fax: (66-2) 288-1030, (66-2) 288-3031

E-mail: escap-sdd@un.org

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хэвлэл

Бангкокт хэвлэв.

2012 оны 11 дүгээр сар